

Төслийн 2023 оны ХАА-ны тайлан  
Төслийн нэр: "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II,III" төсөл  
Төслийн дугаар: BMZ №2016 67 054; BMZ №2018 68 272

"БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ II, III" ТӨСЛИЙН 2023 ОНЫ

(жилийн эцсийн байдлаар)

Огноо: 2023 оны 12 дугаар сарын 15

№	Ула-ны төлөвлөгөөний №	Гэрээний тайлбар (худалдан авах ажил, үйлчилгээ, бараа, зөвлөхийн ажлын дэлгэрэнгүй тайлбар)	Ажил/ Бараа/ Үйлчилгээ/ Зөвлөх	Биелэлт	Хувь
1	2.16	Говийн Их ДЦГ-ын Б хэсгийн хамгаалалтын захиргааны барилга барих	Ажил	Тус ажлыг 2023/Х-2024/ХII хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ хугацаанд дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулж ажиллав. 1. Тус барилгыг барихын тулд дээрх зураг төсөл, төсөв болон БОАЖЯ-ны 2023 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 02/1052 тоот албан бичгээр ирүүлсэн ГИДЦГ-ын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны барилгын концепцийг КfW банкинд хянуулахаар хүргүүлсэн. 2. ТХН. IС Зөвлөх баг, Барилгын зөвлөх багтай тус барилгын ажилд FIDIC гэрээний ямар нөхцлийг сонгож ашиглах талаар хэлэлцэх уулзалтыг 2023.03.07-ны өдөр зохион байгуулсан. 3. ТХН-ээс КfW-д 2023.03.10-ны өдөр төслийн хүрээнд 2023 онд хийхээр төлөвлөж буй барилгын ажлуудад FIDIC гэрээний ямар төрлийг сонгож ашиглах болсон тухай зөвшөөрөл хүссэн албан мэйлийг хүргүүлж 2023.03.20-ны өдөр КfW-аас хариуг мэйлээр хүлээж авсан. 4. БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/512 тушаалыг хүчингүй болгож, БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/67 тушаалаар Үнэлгээний хорооны дарга Н.Батзаяа /Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтсийн дарга/-г өөрчилж А.Энхжаргал /Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн/-г, Үнэлгээний хорооны гишүүн С.Цэндсүрэн /БОЯБХУАӨДЗ төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийн асуудал хариуцсан ажилтан/-г өөрчилж Г.Солонгоо /БОЯБХУАӨДЗ төслийн зөвлөх багийн худалдан авалтын зөвлөх/-г томилсон. 5. Тендерийн үнэлгээний хорооны 01 хурлыг 2023.03.24-ний өдөр зохион байгуулж, тендерийн ажлын даалгавар, тендерийн баримт бичгийн төслийг хэлэлцэж, тендерийн ажлын даалгаврыг БОАЖЯ-наас баталсны дараа тендерийн баримт бичгийн /Англи хэл дээр/ төслийн хамт бэлтгэн, КfW-д хүргүүлж, хянуулж зөвшөөрөл авсны дараа тендер зарлах, Барилгын ажлын төсвийг Барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгэж дахин батлуулах саналыг барилгын зураг төсвийн зохиогч "Бьюдингс Технологи" ХХК-д хүргүүлэхээр шийдвэрлэсэн. 6. Некст степ инженеринг ХХК-аас Барилгын ажлын төсвийг Барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгэж дахин батлуулах саналыг барилгын зураг төсвийн зохиогч "Бьюдингс Технологи" ХХК-д 2023 оны 3 сард хүргүүлсэн ба зураг төсвийн авторас хариу өгөгийг. 7. Тендерийн үнэлгээний хорооны 01 хурлын тэмдэглэл, тендерийн баримт бичиг, ажлын	15
2	2.17, 3.09	Байгаль хамгаалагчийн байр барих (2 багцтай)	Ажил	Тус ажлыг 2023/Х-2024/ХII хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. ҮАТ-ний 1.10, ХААТ-ны 13 дугаар ажил хийгдэж дууссаны дараа тус тендерийг зохион байгуулахаар төлөвлөсөн ч барилгын ажлын зураг төсөл, төсөв нь хийгдээгүй учраас барилгын ажил нь хийгдэх боломжгүй болсон.	0
3	2.06, 3.04	Баруун бүсийн ТХГН-ийн орчны бүсийн сумдын сургуулийн "Эко танхим" байгуулах тавилга, компьютер тоног төхөөрөмжөөр хангах	Бараа	Тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдөр баталсан А/245 дугаартай "Гэрээ байгуулах, хөрөнгө зарцуулах тухай" тушаалын дагуу Хашхан ХХК, Саммит компьютер технологи ХХК-уудын үншлэлтэй 480,315.61 евро буюу 1,822,034,038 төгрөгийн үнийн дүн бүхий 150 хоногийн хугацаанд гүйцэтгэх гэрээг 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан.	100
4	1.05	Төсөлд хамрагдсан ТХГН-ийн ХЗ болон байгаль орчны байгууллагуудыг шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжөөр хангах (2 багцтай)	Бараа	Багц 1: "Үндсэн тоног төхөөрөмж": Захиалагч тендерт шалгарсан "Ай Си Ай Систем Монголиа" ХХК-тай 6427 ширхэг үндсэн тоног төхөөрөмжийг 150 хоногийн хугацаанд 1,561,651,000.00 төгрөгөөр нийлүүлэх бараа нийлүүлэх №23/144 дүгээр гэрээг 2023 оны 07 дугаар сарын 24-ны өдөр байгууллаа. Багц 2: "Оффисын тавилга, IT тоног төхөөрөмж" тендерт шалгарсан "Евро Урлан" ХХК-тай 208 ширхэг оффисын тавилга, IT тоног төхөөрөмжийг 150 хоногийн хугацаанд 284,419,000.00 төгрөгөөр нийлүүлэх бараа нийлүүлэх №23/02 дугаар гэрээг 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр байгууллаа.	100
5	2.08, 3.05	Байгаль орчны байгууллагуудад болон сонгогдсон 7 хамгаалалтын захиргаанд бартаат замын автомашин нийлүүлэх	Бараа	Тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдсан. Захиалагч тендерт шалгарсан "Майнс Ал" ХХК-тай 16 бартаат замын автомашиныг 150 хоногийн хугацаанд 792,000 еврогоор нийлүүлэх гэрээг 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдөр байгууллаа.	100
6	2.09, 3.06	Баруун бүсийн болон сонгогдсон ТХГН-ийн 7 хамгаалалтын захиргааг бусад тээврийн хэрэгслээр хангах (UTV, завьнууд, трактор, хогны машин, бохир соруулах машин) (2 багцтай)	Бараа	Тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдсан. 1-р багц: Протек ХХК-тай 183,709 евро буюу 688,675,439.57 төгрөгийн үнийн дүн бүхий "Завь, 4 дугуйт мотоцикл" нийлүүлэх гэрээг 150 хоногийн хугацаанд гүйцэтгэхээр 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан. 2-р багц: МБ инжиниринг ХХК-тай 471,327.91 евро буюу 1,766,881,076 төгрөгийн үнийн дүн бүхий "Машин, трактор" нийлүүлэх гэрээг 150 хоногийн хугацаанд гүйцэтгэхээр 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан.	100
7	2.10, 3.07	ТХГН-ийн ОБ-ийн сумдыг эмнэлэгийн түргэн тусламжийн машинаар хангах	Бараа	Тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдсан. Захиалагч тендерт шалгарсан "Менххада" ХХК-тай 17 эмнэлгийн түргэн тусламжийн автомашиныг 240 хоногийн хугацаанд 935,000 еврогоор нийлүүлэх гэрээг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр байгууллаа.	100
8	2.11, 3.08	Баруун бүсийн болон сонгогдсон ТХГН-ийн хамгаалалтын захиргаадыг мотоциклоор хангах	Бараа	Тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдсан. Захиалагч тендерт шалгарсан "Протек" ХХК-тай 200 мотоциклыг 150 хоногийн хугацаанд 1,127,225,600 төгрөгөөр нийлүүлэх гэрээг 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр байгууллаа.	100
9	4.06	ТХГН-ийн мэдээллийн сангийн сүлжээ серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Бараа	Захиалагч тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний чадавхыг дээшлүүлэх зорилго бүхий тус ажлын хүрээнд 3 нэр төрлийн нийт 4 ширхэг бараа, түүний програм хангамж, холбогдох үйлчилгээ (суурилуулалт, угсралт, холболт, тохируулга), сургалт (анхан ба ахисан шатны) зохион байгуулах ажлыг 60 хоногийн хугацаанд 146,521,400.00 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр "Ай Ти Зонг" ХХК-тай 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр №23/279 дугаар гэрээг байгууллаа.	100
10	5.01	ТХН, зөвлөх багийн албан хэрэгцээнд шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжөөр хангах	Бараа	Төслийн зөвлөх багаас ажлын даалгавар боловсруулагдан, захиалагчаар батлуулан үнэлгээний хороонд ирэхийг хүлээж байна. Тендерийн үнэлгээний хороог ТНБД-ын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А дугаартай тушаалаар байгуулсан.	15
11	1.01	Төслийн I үе шатны орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг өргөтгөн хэрэгжүүлэх	Зөвлөх үйлчилгээ	Захиалагч тендерт шалгарсан "Эс Ай Си Ай" ХХК-тай Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, Архангай аймгийн Цэнхэр, Ихтамир сум, Завхан аймгийн Их-Уул сум, Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумдуудад (i) ОБЭС-ийн хэрэгжүүлэлтийн үр дүн, үр ашгийг үнэлэх; (ii) Өнөөдрийн байдлаар ОБЭС нь төлөвлөсөн болон төлөвлөөгүй ямар үр дүнг бий болгосныг системтэйгээр үнэлэх; (iii) ОБЭС-г өргөжүүлсэн тохиолдолд чадавхыг бэхжүүлэх ажлыг төлөвлөхөд өмнөх сургажмаасаа суралцахын тулд "Техникийн дэмжлэгийн багц"-ын үр ашгийг системтэйгээр үнэлэх; ажлыг 79,809,500.00 төгрөгөөр 90 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний №23/157 дугаар гэрээг 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдөр байгууллаа.	100
12	1.03	ЮНЕСКО-ийн Хүн ба шим мандлын хөтөлбөрт зарим ТХГН-ийг бүртгүүлэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлэх	Зөвлөх үйлчилгээ	Ажлын даалгавар 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр батлагдлаа. Тус тендерийг 12 дугаар сарын 12-ны өдөр нийтэд зарлан мэдээллээ.	50

13	1.10	Байгаль хамгаалагчийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл боловсруулах	Зөвлөх үйлчилгээ	<p>"Эхэлж зарласан тендерийн явц: Төрийн нарийн бичгийн даргын А/68 дугаар тушаалаар тендерийн үнэлгээний хороо 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр байгуулагдав. Ажлын даалгавар Захиалагчаар 2023-08-17 ны өдөр батлагдлаа. Тендерийн урилгуй үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, вэбсайтууд болон мэдээллийн бусад хэрэгслээр 2023.08.18-ны өдөр нийтэд зарлан мэдээллээ. Санал хүлээн авах эцсийн хугацаа (2023-08-31 10:00 цаг дотор)-н дотор нэг ч компани саналаа ирээгүй. Зөвлөмж, тендерийн үнэлгээний тайланг 2023.09.04-ний өдөр Захиалагчид хүргүүлэн танилцуулснаар Захиалагч тус тендерийг амжилтгүй болсонд тооцов.</p> <p>Дахин зарлах тендер шалгаруулалт: Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт орох тушаалын төслийг Захиалагчаар батлуулахаар ажиллаж байна.Төрийн нарийн бичгийн даргын А/336 дугаар тушаалаар тендерийн үнэлгээний хороонд 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдөр өөрчлөлт орлоо. Үнэлгээний хорооны шинэчлэгдсэн бүрэлдэхүүн 01 тоот хурлаас 10 дугаар сарын 09-ний өдөр зохион байгууллаа. Үнэлгээний хорооны 01 тоот хурлаас гарсан шийдвэр: Ажлын даалгавар дээр Захиалагчаас санал авах, хэлэлцэх зорилготой зохион байгуулагдсан 3 удаагийн хурлаас гарсан Захиалагчийн саналыг шинэчлэн боловсруулсан ажлын даалгаварт тусгаагүй байна гэж Хуулийн хэлтсийн ахлах шинжээч А.Энхжаргалын хэлснийг үндэслэн Төслийн зөвлөх баг дахин зарлах тус тендерийн ажлын даалгаврын концепц, төслийг Захиалагчид танилцуулан батлуулсны дараа үнэлгээний хороо дахин хуралдахаар шийдвэрлэлээ.</p> <p>Төслийн зөвлөх баг 2023 оны 12 дугаар сарын 18-ны 14:00 цагаас Захиалагчид тус тендерийн ажлын даалгаврын танилцуулга хийнэ.</p>	30
14	2.01	Төслийн III үе шатны орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг өргөтгөн хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах	Зөвлөх үйлчилгээ	Үнэлгээний хороо байгуулах тухай тушаал Захиалагчаар баталгаажиг байна. Төслийн зөвлөх баг ажлын даалгаврын төслийг боловсруулан КfW-аар хянуулахаар ажиллаж байна.	хугацаандаа 100
15	2.03	Уур амьсгалын өөрчлөлтөөс хамаарч Монгол Алтайн уулсын өндрийн бүс, бүслүүрийн дагуу ургамлын бүлгэмдлийн шилжилт хөдөлгөөнийг илрүүлэх судалгаа	Зөвлөх үйлчилгээ	Тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр баталсан А/205 дугаартай "Гэрээ байгуулах, хөрөнгө зарцуулах тухай" тушаалын дагуу МУБИС-тай 58,800,000 төгрөгийн үнийн дүн бүхий 5 сарын хугацаанд гүйцэтгэх гэрээг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан.	100
16	2.05, 3.03	Тусгай хамгаалалттай газар нутгийн Орчны бүсийн сумдын сургуулийн "Эко танхим"-ыг сургалтын гарын авлага, багаж хэрэгсэлээр хангаж, сургалт зохион байгуулах	Зөвлөх үйлчилгээ	Захиалагч тендер шалгарсан оролцогч "Байгаль орчны мэдээлэл сургалтын төв" НҮТББ-тай төслийн 2, 3-р үе шатанд төсөл хэрэгжүүлэх ТХГН-ийн Орчны бүсэд байрлах байгаа Ерөнхий боловсролын 75 сургууль болон хамгаалалтын захиргаадад "Эко кабинет" байгуулах, багш нарын чадавжуулах, багаж хэрэгсэлээр хангах ажлыг 737,888,750.0 төгрөгөөр 150 хоногт хугацаанд хийж гүйцэтгүүлэхээр 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдөр №23/158 дүгээр гэрээ байгууллаа.	100
17	2.12	Баруун бүсийн ССМТ-ийн хэрэгцээ шаардлагын судалгаа хийж, үзэл баримтлалыг боловсруулах	Зөвлөх үйлчилгээ	Тус ажлыг 2023/VIII-2023/X хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ хугацаанд ажлын даалгаврын төслийг IC зөвлөх баг боловсруулж КfW-д хянуулж зөвшөөрөл авахаар хүргүүлсэн боловч КfW-аас зөвшөөрөөгүй тул тус ажлыг зохион байгуулаагүй болно. Тендерийн үнэлгээний хороог ТНБД-ын 2023.11.02-ны өдрийн А/378 дугаартай тушаалаар байгуулсан.	15
18	2.14	Монгол Элсний ТХГН-т хамаарагддаг Эрээн нуурыг сэргээх ажлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох	Зөвлөх үйлчилгээ	Тус төсөл арга хэмжээг Сангийн сайдын багцаас, улсын төсвийн хөрөнгөөр хийхээр болсон тул тендер шалгаруулалтыг төслийн зүгээс зохион байгуулахгүй.	хойшилсон үнэлэхгүй
19	2.15	Говийн Их ДЦГ-ын Б хэсгийн барилгын одоогийн зураг төсөв, зардлын тооцоог шинэчлэх	Зөвлөх үйлчилгээ	Тендерийн үнэлгээний хороог ТНБД-ын 2023.11.02-ны өдрийн А/377 дугаартай тушаалаар байгуулсан. Ажлын даалгавар 2023.11.28-ны өдөр захиалагчаар батлагдсан. Тус ажил нь барилгын зургийн авторын эрхтэй ажил тул гэрээ шууд байгуулах зөвлөмжийг БОАЖЯ-ны ТНБД-д 2023.12.08-ны өдөр танилцуулж, 2023.12.14-ний өдөр зөвшөөрөл авав. Захиалагчаас Бьюдингс Технологи ХХК-д 2023.12.14-ний өдөр гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл, гэрээний төслийг хүргүүлэв. Гэрээ байгуулах шатанд байна.	80
20	4.03	Байгаль хамгаалагчийн сургалтын хөтөлбөрийн дагуу судалгаа, мониторингийн сургалт зохион байгуулах	Зөвлөх үйлчилгээ	Захиалагчаар ажлын даалгавар 2023 оны 11 дүгээр сарын 15-нд батлагдсан. Тендерийн үнэлгээний хороог ТНБД-ын 2023 оны 10 дугаар сарын 02-ны А/320 тоот тушаалаар байгуулсан. Үнэлгээний хорооны №01 тоот хурлыг 2023 оны 12 дугаар сарын 06-нд хийхэд үнэлгээний хорооны дарга болон гишүүн тендерийн үнэлгээний хороонд ажиллахаас татгалзсантай холбоотойгоор үнэлгээний хорооны тушаалд өөрчлөлт орох тушаалын төсөл холбогдох дарга нарт танилцуулагдаж байна.	30
21	4.04	Төслийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх контент боловсруулах, танилцуулах	Зөвлөх үйлчилгээ	Тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдсан. Захиалагч тендер шалгарсан "И Эм Технологи" ХХК-тай контент хийх зөвлөх үйлчилгээний гэрээг 60 хоногийн хугацаанд 50,100,000 төгрөгөөр нийлүүлэх гэрээг 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр байгууллаа.	100
22	4.07	Монгол орны ТХГН-ийн сүлжээний хэмжээнд мэдээллийн санг стандартын дагуу байгуулах	Зөвлөх үйлчилгээ	Тендерийн үнэлгээний хороог ТНБД-ын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/321 дугаартай тушаалаар байгуулсан. Ажлын даалгаврыг 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр БОАЖЯ-ны ТНБД баталсан. Үнэлгээний хорооны №01 тоот хурлыг 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Тус ажил нь зохиогчийн эрхтэй ажил тул гэрээ шууд байгуулах зөвлөмжийг БОАЖЯ-ны ТНБД-д 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр танилцуулж, тухайн өдөр зөвшөөрөл авав. Захиалагчаас "Бит Софт" ХХК-д 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдөр гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл, гэрээний төслийг хүргүүлэв. ХII сард батгаж Монгол орны ТХГН-ийн сүлжээний нэгдсэн цахим хуудас www.mpa.gov.mn болон 33 хамгаалалтын захиргааны цахим хуудсуудын загвар дизайныг сайжруулах, шинээр байгуулагдсан 7 хамгаалалтын захиргааны цахим хуудсыг шинээр нэмж хийх ажлын гэрээг шууд байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	80
23	5.02	БОЯБХУАӨДЗ Төслийн цахим хуудсыг шинэчлэх, мониторингийн мэдээллийн сан байгуулах	Зөвлөх үйлчилгээ	Захиалагч тендер шалгарсан "Идеадэвелопмент" ХХК-тай "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох" төслийн цахим хуудсыг шинэчлэх, олон нийтэд үйл ажиллагааг нь өргөнөөр танилцуулах, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, төслийн үндсэн баримт бичгүүдийн санг үзэгсэж мониторингийн мэдээллийн сан байгуулах зэрэг ажлуудыг 60 хоногийн хугацаанд хийлгүүлэх зөвлөх үйлчилгээний №23/248 дугаар гэрээг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр байгууллаа.	100
24	M02	Говийн Б хэсгийн ДЦГ-ын хамгаалалтын захиргааны барилгын талбайд археологийн судалгаа хийх	Зөвлөх үйлчилгээ	IC Зөвлөх баг Археологийн хүрээлэнтэй 2023.09.15-ны өдөр 6,966,300 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ байгуулж, 2023.09.29-ний өдөр ажлаа гүйцэтгэж дууссан.	100
25	M04	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулахад дэмжлэг үзүүлэх	Зөвлөх үйлчилгээ	Захиалагч тендер шалгарсан оролцогч "Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийн судалгаа хөгжлийн төв" НҮТББ-тай Байгаль орчинд нөлөөлөл байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хуулийн үзэл баримтлалын төсөл боловсруулах, талуудын оролцоотой хэлэлцүүлгийг үе шаттай зохион байгуулах, ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх, саналыг тусгах, хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотой бусад хуулийн төсөл, дагаж гарах журмын төсөл боловсруулах, гэрээний хугацаанд хуулийн төслийг захиалагчид БОАЖ-ын сайдын зөвлөл болон ажлын хэсэг/ танилцуулж санал, зөвлөмж, чиглэлийг тусгах ажлыг 60 хоногийн хугацаанд гүйцэтгэхгүйлэх №23/158 дугаар гэрээг 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдөр байгууллаа.	100

ХАА-ны мониторингоор нийт төлөвлөсөн 25 тендерээс бүрэн хэрэгжсэн, гэрээ байгуулсан 100%=15, гэрээ байгуулах шатандаа 80%=2, тендер зарласан 50%=1, ҮХ байгуулсан, АД баталсан 30%=2, ҮХ байгуулсан 15%=3, хийгдээгүй 0%=1